

**БАЙГАЛЬ ОРЧИН, АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ЯАМНЫ “ШИЛЭН ДАНСНЫ ТУХАЙ” ХУУЛИЙН  
ХЭРЭГЖИЛТИЙН 2017 ОНЫ 4 ДҮГЭЭР УЛИРЛЫН БОЛОН ЖИЛИЙН ЭЦСИЙН ТАЙЛАНД  
ХИЙСЭН ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ТАНИЛЦУУЛГА**  
/2017 оны 4 дүгээр улирлын болон жилийн эцсийн байдлаар/

2018 оны 01 дүгээр сарын 25-ны өдөр

Улаанбаатар хот

**Нэг: Хяналт-шинжилгээ, үнэлгээний зорилго**

“Шилэн дансны тухай” хууль, “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын хэрэгжилтэд 2017 оны 4 дүгээр улирал болон жилийн эцсийн мэдээнд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, дүгнэлт, зөвлөмж гаргах зорилготой бөгөөд холбогдох мэдээллийг олон нийтэд мэдээлсэнээр төсвийн ил тод байдлыг хангах, төсвийн хэрэгжилтэд иргэдээс хяналт тавих нөхцлийг бий болгох ач холбогдолтой ажил юм.

**Хоёр. Ажлын хэсгийн бүрэлдэхүүн, хугацаа**

“Шилэн дансны тухай” хууль, “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын хэрэгжилтэд Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газрын мэргэжилтэн Б.Одбаяр 2018 оны 01 дүгээр сарын 17-ны өдрөөс 01 дүгээр сарын 25-ний өдрийг дуустал хугацаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, холбогдох баримт материалыг нягтлан шалгаж дүгнэв.

**Гурав. Хуулийн хэрэгжилтийн хамрах хүрээ**

1. Байгаль орчин, аялал жуулчлалын яам нь “Шилэн дансны тухай” хуулийн дагуу төсвийн ерөнхийлөн захирагчийн 1, төсвийн төвлөрүүлэн захирагчтай 1, төсвийн шууд захирагч 81, төсөл хөтөлбөр 9 нийт 92 байгууллагууд мэдээллээ өөрийн цахим хуудас болон shilendans.gov.mn сайт, мэдээллийн самбараар иргэд, олон нийтэд мэдээлж байна.

2. Төсвийн шууд захирагч нар байгууллагын шилэн дансны мэдээллийг улирал бүр shilendans.gov.mn сайтад байршуулж, Сангийн яаманд тайлангаа цахимаар хүргүүлж байна.

3. Төсвийн ерөнхийлөн захирагч нар “Шилэн дансны тухай” хуульд хамаарах 18 төрлийн мэдээлэл, Төсвийн шууд захирагч нар 20 төрлийн мэдээлэл нийт 38 мэдээллийг байршуулахаар заасан нь хугацаа болон мэдээллийн агуулгаас хамааран бүтэн жилээр, хагас жилээр, улирал бүр, сар бүр, тухай бүр оруулах мэдээлэл зэргээр 5 бүлгээр мэдээлэх үүрэгтэй.

**Дөрөв. Тайлант хугацаанд гүйцэтгэсэн ажлын үр дүн, хуулийн хэрэгжилтийн явц**

**4.1. Төсвийн шууд захирагчийн мэдээлэл:**

Төсвийн ерөнхийлөн захирагчийн батлагдсан төсөвт 2017 оны 4 дүгээр улирлын болон жилийн эцсийн байдлаар Шилэн дансны хуулийн хэрэгжилтэд байгууллага тус бүрээр shilendans.gov.mn сайтаас нягтлан баталгаажуулахад төсвийн шууд захирагч/91/-дын цахим сайтад байршуулах 20 төрлийн нийт 1820 мэдээллийг хугацааны ангилалаар нэгтгэн дараах хүснэгтэд харуулав. Үүнд: /Хавсралт 1-2-ийн мэдээллийг хавсралт 1-д нэгтгэн дүгнэв/.

№	Хугацааны ангилал	Байршуулсан мэдээлэл	
		тоо	Хувь
1	Хугацаандаа оруулсан	1326	72.9%
2	Хугацаа хоцорч оруулсан	164	9.0%
3	Хуулийн хугацаа болоогүй	182	10.0%
4	Огт оруулаагүй	148	8.1%

**4.2. Төсвийн ерөнхийлөн захирагчийн мэдээлэл:**

Төсвийн Ерөнхийлөн захирагчийн 18 төрлийн бүтэн жил, хагас жил, улирал бүр, сар бүр, тухай бүр оруулах 42 мэдээг “Шилэн дансны цахим хуудсанд тавигдах мэдээллийн агуулга,

нийтлэг стандартыг тогтоох тухай журам”-д заасны дагуу мэдээлэл оруулах шаардлагатайгаас 17 мэдээлэл хугацаа хоцорсон, 2 мэдээлэл оруулах хугацаа болоогүй байна. / Хавсралт 2/

### **Тайлант хугацаанд гүйцэтгэсэн ажлын үр дүн, хуулийн хэрэгжилтийн явцыг нэгтгэн дүгнэхэд:**

1. Нийт байгууллагын 82.5 хувь нь 2017 оны 4 дүгээр улирлын тайланг “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын 8.1 заасан хугацаанд буюу дараа сарын 15-аас өмнө байгууллагын нэгдсэн админд цахим хэлбэрээр илгээсэн байна.

2. “Шилэн дансны тухай” хуулийн хэрэгжилт 2017 оны 1 дүгээр улиралд 96.5%, 2 дугаар улиралд 86.3 %, 3 дугаар улиралд 93.3%, 4-р улирлын байдлаар 87.1% буюу 2017 оны жилийн эцсийн байдлаар 90.8% дүгнэгдэв.

### **Тав. Дүгнэлт**

1. “Шилэн дансны тухай” хуулийн хэрэгжилт 2017 оны жилийн эцсийн байдлаар 92.0% дүгнэгдэж, 2016 оны жилийн эцсийн мөн үеийнхтэй харьцуулхад 13.7%-ийн өсөлттэй байгаа нь хуулийн хэрэгжилт харьцангуй сайн хэрэгжсэн гэж дүгнэж байна.

2. Төсвийн ерөнхийлөн захирагчийн болон төсвийн шууд захирагчдын shilendans.gov.mn сайтад байршуулсан мэдээлэл, хуулийн хэрэгжилтэд хяналт-шинжилгээ хийхэд дараах байдлаар үнэлэгдэв. Үүнд:

2.1. Мэдээллээ үнэн, зөв, хугацаанд нь оруулсан 5 байгууллага:

- Байгаль орчин, уур амьсгалын сан
- Хар ус нуур УТХГ-ын хамгаалалтын захиргаа
- Дорнодын УТХГ-ын хамгаалалтын захиргаа
- Хангайн нурууны БЦГ-ын хамгаалалтын захиргаа
- Хөгнө тарнийн БЦГ-ын хамгаалалтын захиргаа

2.2. Мэдээллийн чанар, хуулийн хэрэгжилт хангалтгүй 7 байгууллага:

- Байгаль орчин аялал жуулчлалын яамны аппарат
- Хэнтий аймгийн Ус цаг уур орчны шинжилгээний газар
- Үенч бодонч булган голын сав газрын захиргаа
- Говийн их ДЦГ-ын Б хэсгийн хамгаалалтын захиргаа
- Мянган угалзатын нурууны БЦГ-н хамгаалалтын захиргаа
- Байгалийн нөөцийн менежмент бүхий хамгаалалттай газар нутгийн сүлжээ төсөл
- Монгол орны баруун бүсэд газрын доройтол, хөгжлийн сөрөг нөлөөллийг бууруулах дүйцүүлэн хамгааллыг нэвтрүүлэх нь төсөл

3. Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг биелүүлэх үүргээ хангалтгүй хэрэгжүүлсэн, мэдээллээ цаг хугацаандаа оруулаагүй дээрх 7 байгууллагын эрх бүхий албан тушаалтнуудад холбогдох хууль тогтоомжийн дагуу арга хэмжээ авч ажиллах нь зүйтэй гэж дүгнэв.

### **Зургаа. Зөвлөмж**

*БОАЖЯ-ны Санхүүгийн хэлтэс болон төсвийн шууд захирагч, нягтлан бодогч нарт зөвлөмж хүргүүлэх нь:*

1. Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг хэвшүүлэх талаар үүрэг хүлээсэн байгууллага, албан тушаалтнууд нь хуулийн хэрэгжилтэд тавих байгууллагын дотоод хяналтыг чангатган, ажлын сахилга хариуцлагыг сайжруулах;

2. Үндэсний аудитын газрын 2017 оны “Шилэн дансны тухай” хуулийн хэрэгжилтэд хийсэн нийцэлийн аудитын дүгнэлтийн дагуу гарсан зөрчлийг арилгах;

3. Тухайн байгууллагын дарга болон нягтлан бодогч солигдсон бол байгууллагын админ эрхээрээ орж, холбогдох мэдээллийг тухай бүр шинэчлэх;

4. “Шилэн дансны тухай” хуулийн хэрэгжилтэд улирал бүр дотоод аудит, хяналт шинжилгээ хийхээр Сангийн сайдаас үүрэг өгөгдсөн тул мэдээллээ хуулийн хугацаанд үнэн зөв, бодитоор/долоо хоног, сар, улирал, хагас бүтэн жил/ тогтмол оруулж хэвших;

5. “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын 8.1 дэхь заалтын дагуу журмын хэрэгжилтийн улирлын тайланг байгууллагын нэгдсэн админд тогтмол илгээх;

6. “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын хавсралтад заасан хүснэгтийн дагуу мэдээллээ PDF, XML форматаар цахимаар архивлаж, холбогдох тайлбарыг бүрэн оруулж шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд оруулж хэвших;

7. Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг биелүүлэх үүргээ хангалтгүй хэрэгжүүлсэн, мэдээллээ цаг хугацаандаа оруулаагүй дээрх 7 байгууллагын эрх бүхий албан тушаалтнуудад холбогдох хууль тогтоомжийн дагуу арга хэмжээ авч ажиллах;

8. “Шилэн дансны тухай” хууль, “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын хэрэгжилтэд улирал бүр хийсэн хяналт-шинжилгээ, үнэлгээний дүгнэлт, зөвлөмжийн хэрэгжилтийг ханган, хариуг албан бичгээр хүргүүлж баталгаажуулах, төсвийн ил тод байдлыг хангах, төсвийн хэрэгжилтэд иргэдээс хяналт тавих нөхцлийг бий болгох үүргээ биелүүлэн ажиллах шаардлагатай байна.

ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ ДОТООД АУДИТЫН ГАЗАР

**ТӨСВИЙН ШУУД ЗАХИРАГЧДЫН 2017 ОНЫ 4 ДҮГЭЭР УЛИРЛЫН ШИЛЭН ДАНСНЫ ЦАХИМ  
ХУУДСАНД ОРУУЛСАН МЭЛЭЭЛЛИЙН НЭГДСЭН ДҮН**

*Хавсралт 1*

№	Мэдээллийн агуулга	Хугацаандаа оруулсан	Хугацаа хоцорсон	Хугацаа болоогүй	Оруулаагүй мэдээлэл
1	Төсвийн байгууллагын батлагдсан төсөв	83	3		5
2	Тухайн жилийн төсөвт орсон нэмэлт, өөрчлөлт	77	8		6
3	Өмнөх оны төсвийн зарлагын хэмнэлт, туслах үйл ажиллагааны орлогоос давсан хэсгийг урамшуулалд зарцуулсан тайлан	70	2		19
4	Хандив, тусламжийн хэмжээ, түүний зарцуулалтын тайлан	64	1		26
5	Цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээ	78	8		5
6	Санхүүгийн тайлан			91	
7	Санхүүгийн тайланд хийсэн аудитын дүгнэлт			91	
8	Байгууллагын батлагдсан төсөв	56	29		6
9	Худалдан авах ажиллагааны төлөвлөгөө	53	34		4
10	Хөрөнгийн зардал, хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний төлөвлөгөө, концессын зүйлийн жагсаалт гүйцэтгэл	78	7		6
11	Хөрөнгийн болон урсгал зардалд тусгагдсан арга хэмжээний тендерийн ерөнхий мэдээлэл	81	5		5
12	Таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий худалдан авсан бараа, ажил үйлчилгээний нэр, санхүүжилтийн хэмжээ, нийлүүлэгчийн нэр,	79	6		6
13	Худалдан авах ажиллагааны тайлан	76	2		13
14	Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 8, 9 дүгээр зүйлд заасан мэдэгдэл	75	6		10
15	Бонд, Зээл, өрийн бичиг баталгаа, түүнтэй адилтгах санхүүгийн бусад хэрэгсэл болон төр, хувийн хэвшлийн хүрээнд байгуулсан гэрээ, концесс, төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах, өр, авлага үүсгэсэн аливаа шийдвэр	79	8		4
16	Аудитын тайлан, дүгнэлт, зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний тайлан	62	17		12
17	Тухайн байгууллага хууль тогтоомжийн дагуу төвлөрүүлэх төлбөр, хураамж, зохицуулалтын үйлчилгээний хөлсний хэмжээнд орсон өөрчлөлтийн шийдвэр	79	6		6
18	Байгууллагын батлагдсан орон тоонд орсон өөрчлөлт	85	2		4
19	Худалдан авах ажиллагаанд хийсэн аудитын тайлан, дүгнэлт болон бусад хяналт шалгалтын дүн	82	3		6
	<b>Нийт</b>	<b>1326</b>	<b>164</b>	<b>182</b>	<b>148</b>

